

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/15/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: В.Эрдэнэцогт

Утас:260512 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Долгоржав

Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn

Өлзийт экаунт аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал: Ч.Эрдэнэжав

Утас:88117655 Цахим хаяг: auditulziit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	13
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
5.1 Албан шаардлага.....	19
5.2 Зөвлөмж.....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХТ	Барилгын хөгжлийн төв
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа , ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал ы ахуй
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.23 № 06/772
танай _____-ны № _____-т

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.МӨНХБААТАР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 333.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Инженер техникийн ажилтны сургалтыг аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг компаниар зохион байгуулж 95.8 сая төгрөг зарцуулсан;
- Төсвийн хөрөнгөөр "BIM-ын олон улсын туршлага, гарах үр дүн сэдэвт сургалт зохион байгуулах" тендерийг жил бүр 59.6 сая төгрөгөөр зохион байгуулж, зардлыг хэмнэж ажиллаагүй;
- Тайлангийн хугацаанд 49.2 сая төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог бодож, тайлан гаргаагүй;
- Инженерийн энгэрийн тэмдгийн үлдэгдэл 3053 ширхэг байхад нэмж 2000 ширхгийг 46.0 сая төгрөгөөр худалдан авч их хэмжээний нөөц үүсгэсэн;
- Урьдчилж орсон сургалтын төлбөрийн хуримтлагдсан өр 19.0 сая төгрөгийг жилийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.10, 7.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д зүйлийн 13 дугаар зүйлийн 13.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д гэсэн заалттай нийцээгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдаж буй 2584 барилга байгууламж, дэд бүтцийн ажлын зураг төсөлд магадлал хийх, дүгнэлтийг баталгаажуулсан, улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй 487 төсөл арга хэмжээний захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн, “Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах 7 үе шаттай ажлыг тус тус гүйцэтгэж, захиалагчид хүлээлгэн өгсөн байна.

Мөн 2 аймгийн 11 сумын төвийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах 1,609.5 сая төгрөгийн гэрээ байгуулан зураглал, тайлбар бичгийг боловсруулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус төв нь “Эрдэнэс таван толгой” ХК-ийн захиалгаар нүүрс тээврийн конвейер, бутлуур, ачилтын барилга байгууламжийн ажил, нүүрс баяжуулах үйлдвэрийн төсөл, Монголын газрын тос боловсруулах үйлдвэрийн захиалгаар газрын тос дамжуулах хоолой барих төсөл, Улаанбаатар хотын цэвэрлэх байгууламжийг барих төсөл зэрэг Засгийн газрын хэрэгжүүлж буй мега төслүүдийн захиалагчийн техникийн хяналт, зураг төслийн хяналтын ажлуудыг хийж, 27,066.9 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Бусад асуудал

Барилга хөгжлийн төвийн санхүүгийн тайланд Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар баталсан Барилгын норм, нормативын сангийн дансны мөнгөн хөрөнгө нэгтгэгдэж байна. Уг сан нь барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн судалгаа хийх, боловсронгуй болгох, үндэсний норм нормативын баримт бичгийг боловсруулах, батлуулах болон хэвлүүлэх, сурталчлахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулах зорилготой бөгөөд тайлант онд нийт 8,951.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 01-р сарын 01	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	34,456,517,306.17	39,129,184,281.69
1.1.2	Дансны авлага	2,480,425,801.70	3,210,607,427.13
1.1.4	Бусад авлага	121,500,000.00	177,423,000.00
1.1.6	Бараа материал	309,698,327.99	359,776,277.10
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	37,368,141,435.86	42,876,990,985.92
1.2.1	Үндсэн хөрөнгө	10,052,427,544.26	10,754,324,588.62
1.2.2	Биет бус хөрөнгө	1,381,842,299.03	1,292,170,219.14
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,434,269,843.29	12,046,494,807.76
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	48,802,411,279.15	54,923,485,793.68
2.1.1.1	Дансны өглөг	5,867,738,662.77	4,434,306,760.66
2.1.1.3	Татварын өр	441,347,173.23	591,457,143.28
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	21,714,403,931.69	27,017,456,493.58
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	1,632,308,822.78	1,654,706,059.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	29,655,798,590.47	33,697,926,456.52
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.3.1	Өмч:-төрийн	8,159,338.00	8,159,338.00
2.3.4	Нэмж төлөгдсөн капитал	195,479,515.00	195,479,515.00
2.3.7	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,337,339,884.99	1,337,339,884.99
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	6,454,791,998.45	6,484,791,998.45
2.3.9	Хуримтлагдсан ашиг	11,150,841,952.24	13,199,788,600.72
2.3.11	Эздийн өмчийн дүн	19,146,612,688.68	21,225,559,337.16
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	48,802,411,279.15	54,923,485,793.68

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	25,825,141,892.50	28,317,374,548.35
2	Борлуулалтын өртөг	175,604,215.03	144,942,535.32
3	Нийт ашиг (алдагдал)	25,649,537,677.47	28,172,432,013.03
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүгийн орлого	3,134,293,072.55	2,045,837,056.94
6	Ерөнхий ба удирдлагын зардал	24,401,984,367.22	25,634,885,515.29
7	Бусад зардал	-	128,883,070.52
8	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(4,080,993.53)	2,361,525.26
9	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(17,256,155.01)	-
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,360,509,234.26	4,456,862,009.42
11	Орлогын татварын зардал	436,050,923.43	445,686,200.94
12	Татварын дараах ашиг (алдагдал)	3,924,458,310.83	4,011,175,808.48
13	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,924,458,310.83	4,011,175,808.48

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.0	195,479,515.0	1,337,339,884.99	6,454,791,998.4	7,606,120,321.41	15,601,891,057.85
Залруулсан үлдэгдэл	8,159,338.0	195,479,515.0	1,337,339,884.99	6,454,791,998.45	7,606,120,321.41	15,601,891,057.85
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	3,924,458,310.83	3,924,458,310.83
Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	379,736,680.00	379,736,680.00
2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	8,159,338.0	195,479,515.0	1,337,339,884.99	6,454,791,998.45	11,150,841,952.24	19,146,612,688.68
Залруулсан үлдэгдэл	8,159,338.0	195,479,515.0	1,337,339,884.99	6,454,791,998.45	11,150,841,952.24	19,146,612,688.68
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	4,011,175,808.48	4,011,175,808.48
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	30,000,000.00	-	30,000,000.00
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	1,962,229,160.00	1,962,229,160.00
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	8,159,338.0	195,479,515.0	1,337,339,884.99	6,484,791,998.45	13,199,788,600.72	21,225,559,337.16

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	50,445,498,562.94	48,209,201,733.97
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	47,776,916,464.91	47,827,793,954.10
1.1.2	Үндсэн үйл ажиллагааны бусад мөнгөн орлого	2,668,582,098.03	381,407,779.87
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	42,094,209,311.74	44,123,638,680.20
1.2.1	Ажиллагчдад төлсөн	10,598,235,003.71	11,674,079,930.64
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,550,939,555.71	3,889,661,940.51
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,322,827,865.06	1,978,288,104.07
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	130,139,668.85	165,508,922.60
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	453,291,072.88	272,138,372.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,376,036,289.91	2,798,776,113.47
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	26,891,952.00	7,985,513.00
1.2.9	Үндсэн үйл ажиллагааны бусад мөнгөн зарлага	23,635,847,903.62	23,337,199,783.91
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	8,351,289,251.20	4,085,563,053.77
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,979,663,904.69	2,208,164,840.77
2.1.1	Хүлээн авсан хүүний орлого	1,979,663,904.69	2,208,164,840.77
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(310,392,124.31)	584,984,636.77
3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	(4,080,993.53)	2,119,284.98
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,036,816,133.36	4,672,666,975.52
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,419,701,172.81	34,456,517,306.17
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,456,517,306.17	39,129,184,281.69

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

"БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР, КОМПАНИЙН 2025 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Х/н	2024 он	2025 он		Харьцуулалт			
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйцэт	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:			28,959,434.95	30,265,351.71	30,363,211.60	1,403,776.65	104.85	97,859.89	100.32
1	Захиалагч хяналтын орлого	м.төг	18,809,445.20	22,061,264.89	21,269,917.89	2,460,472.69	113.08	(791,347.00)	96.41
	Нормчлолтой холбоотой орлого	м.төг	1,196,097.50	1,004,597.50	953,953.49	(242,144.01)	79.76	(50,644.01)	94.96
	Инженер техникийн ажилтны сургалтын орлого	м.төг	652,638.18	330,700.00	237,957.32	(414,680.86)	36.46	(92,742.68)	71.96
	Бүтээгдэхүүн баталгаажуулалтын орлого	м.төг	105,956.94	78,500.00	137,004.65	31,047.71	129.30	58,504.65	174.53
	Зураг төсөл, магадлалын орлого	м.төг	4,246,502.85	3,200,000.00	4,159,630.93	(86,871.92)	97.95	959,630.93	129.99
	Лабораторийн орлого	м.төг	564,401.08	844,800.00	637,322.10	72,921.02	112.92	(207,477.90)	75.44
	Бусад орлого	м.төг	3,384,393.20	2,745,489.32	2,967,425.22	(416,967.98)	87.68	221,935.90	108.08
2	Нийт орлого	м.төг	28,959,434.95	30,265,351.71	30,363,211.60	1,403,776.65	104.85	97,859.89	100.32
3	Нийт зардал	м.төг	24,577,588.58	28,369,483.61	25,779,828.05	1,202,239.47	104.89	(2,589,655.56)	90.87
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	674,753.32	981,210.35	863,635.14	188,881.82	127.99	(117,575.20)	88.02
4	Татварын өмнөх ашиг	м.төг	4,360,509.23	1,889,868.10	4,456,862.00	96,352.77	102.21	2,566,993.90	235.83
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	3,924,458.31	1,700,881.29	4,011,175.80	86,717.49	102.21	2,310,294.51	235.83
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	5,953,242.75	6,589,133.23	6,690,282.63	737,039.88	112.38	101,149.40	101.54

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	а/ Орлогын татварт	м.төг	436,050.92	188,986.81	445,686.20	9,635.28	102.21	256,699.39	235.83
	б/ НӨТ	м.төг	-	-	-	-	-	-	-
	в/ НДШ	м.төг	3,546,430.01	4,312,418.45	3,883,922.35	337,492.34	109.52	(428,496.10)	90.06
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	1,883,937.52	1,985,562.97	2,107,917.98	223,980.46	111.89	122,355.01	106.16
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	38,362.50	38,362.50	38,362.80	0.30	100.00	0.30	100.00
	з/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	1,990.38	6,500.00	6,211.97	4,221.59	312.10	(288.03)	95.57
	ж/ Бусад татварт (улсын тэмдэгийн хураамж)	м.төг	46,471.42	57,302.50	208,181.33	161,709.91	447.98	150,878.83	363.30
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	1,962,229.16	656,353.54	1,203,115.14	(759,114.02)	61.31	546,761.60	183.30
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	271.00	273.00	222.00	(49.00)	81.92	(51.00)	81.32
9	Нийт цалингийн сан	м.төг	12,369,897.52	14,746,385.00	14,360,410.42	1,990,512.90	116.09	(385,974.58)	97.38
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	3,803.78	3,916.55	5,390.54	1,586.76	141.72	1,473.99	137.64
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.85	0.94	0.85	0.00	100.05	(0.09)	90.58
12	Хөрөнгө оруулалт	м.төг	2,428,270.80	2,258,578.10	1,681,441.56	(746,829.24)	69.24	(577,136.54)	74.45
13	Нийт авлага	м.төг	2,601,925.80	2,500,000.00	3,388,030.42	786,104.62	130.21	888,030.42	135.52
	Үүнээс: Найдваргүй	м.төг	-	-	-	-	-	-	-
14	Нийт өглөг	м.төг	29,655,798.59	21,395,000.00	33,697,926.45	4,042,127.86	113.63	12,302,926.45	157.50
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	29,655,798.59	21,395,000.00	33,697,926.45	4,042,127.86	113.63	12,302,926.45	157.50
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	-	-	-	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ нь “Барилгын салбарын хөгжлийг түргэтгэгч, дэмжин туслагч, түншлэгч байгууллага байна” гэж зорилгоо тодорхойлж, барилга байгууламжийн норм, норматив боловсруулах, зураг төсөлд магадлал хийх техникийн хяналт тавих, сургалт, судалгаа хийх үндсэн чиг үүрэгтэй Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Барилга хөгжлийн төв ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны чиглэл дүрмийг Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор баталсныг мөрдөн ажилладаг. Үүнд:

- Салбарын хууль тогтоомж, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Барилгын норм, норматив, дүрэм, барилгын төсвийн жишиг үнэлгээ, үнийн индекс, стандарт боловсруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх;
- Барилгын норм нормативын сангийн хөрөнгөөр боловсруулах норм, норматив, төсөл арга хэмжээний төлөвлөгөөний дагуу барилгын норм, дүрмийг боловсруулах ажлыг зохион байгуулах;
- Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх ажлыг зохион байгуулах;
- Инженер техникийн ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх, сургалтуудыг зохион байгуулах;
- Барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, баяжилт хөтлөлт хийх, мэдээ мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
- Барилга нийтийн аж ахуйн салбарын хүний нөөцийн бодлого, зорилтыг сургалтын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх;
- Салбарын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангуулах;
- Улсын төсөв болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд техникийн хяналт гүйцэтгэх;
- Орон сууцны хувьчлал, мэдээллийн санг бүрдүүлэх, иргэд байгууллагуудыг мэдээллээр хангах;
- Салбарын бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон судалгаа, мэдээллийн сан үүсгэх ажлыг зохион байгуулах;
- Барилгын материал, хийц бүтээцийн дээжид сорилт шинжилгээ хийх, дүгнэлт гаргах гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ нь Монгол улсын Засгийн газрын 2012 оны 47 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “Газрын харилцаа, барилга, геодизи, зураг зүйн газрыг татан буулгасантай холбогдуулан барилгын чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий газар болж байгуулагдсан байна. ТӨБЗГ-ын 2025 оны 641 дүгээр тогтоолоор бүтэц, орон тоог баталсны дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Улсын төсөв болон гадаадын зээл, тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжсэн 487 төсөл арга хэмжээнд захиалагчийн техник хяналтыг зөвлөх болон мэргэшсэн мэргэжлийн инженерүүдийн багийн бүрэлдэхүүнээр гүйцэтгэсэн.

“Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”-ийн хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах барилга байгууламж, бүх төрлийн дэд бүтцийн ажлын зураг төсөлд магадлал хийх хүсэлтийн дагуу нийт 2696 ажлын гэрээ байгуулан барилга байгууламжийн ажлын зураг төсөл, төсөвт магадлал хийх ажлыг зохион байгуулж, 2584 ажлыг дүгнэлтийн нэгтгэлээр баталгаажуулсан байна. Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1291, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1293, инженер геологийн судалгааны 2440 дүгнэлтийг баталгаажуулсан байна. Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яам, Эдийн засаг, хөгжлийн яам, “Бүсчилсэн хөгжлийн хүрээлэн” УТҮГ-ын захиалгатай, нийт 83 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 01 тоот “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах, бүтээмжийг дээшлүүлэх” албан даалгавар;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд өөрчлөлт орсон;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон.

Тус төвийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ -ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,121.1 сая төгрөгөөр буюу 12.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	34,456,517.3	39,129,184.3	4,672,667.0
Авлага	2,601,925.8	3,388,030.4	786,104.6
Бараа материал	309,698.3	359,776.3	50,078.0
Үндсэн хөрөнгө	11,434,269.8	12,046,494.8	612,225.0
Нийт хөрөнгө	48,802,411.3	54,923,485.8	6,121,074.5
Өр төлбөр	29,655,798.6	33,697,926.5	4,042,127.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	19,146,612.7	21,225,559.3	2,078,946.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	48,802,411.3	54,923,485.8	6,121,074.5

Өмнөх оны үзүүлэлтүүдээс материаллаг өөрчлөлт орсон мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данстууд байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,672.7 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа мега төсөл хөтөлбөрүүдийн барилгын төсөвт өртөлт магадлал болон захиалагчийн хяналт хэрэгжүүлсний орлого, болон хүүгийн орлого голлон нөлөөлжээ.

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 786.1 сая төгрөгөөр өссөн тайлант оны эцэст Худалдаа Хөгжлийн банк, Голомт банканд байршуулсан хөрөнгийн баталгааны авлагын үлдэгдэл 2,966.4 сая төгрөг, Монголын газрын тос боловсруулах үйлдвэр 113.0 сая төгрөг, Хавдар судлалын үндэсний төв 42.1 сая төгрөг, Эрчим хүчний салбартай холбоотой 143.2 сая төгрөг, аж ахуйн нэгж байгууллагатай холбоотой 123.3 сая төгрөгийн авлагуудын гэрээний хугацаа болон ажил үйлчилгээ нь бүрэн дуусаагүйгээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 50.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд худалдан авсан 298.6 сая төгрөгийн шатах тослох материал, 1,417.0 сая төгрөгийн хангамжийн материал, 315.0 сая төгрөгийн норм, дүрмийн ном сэтгүүл бэлтгэж, үйл ажиллагаандаа 1,980.5 сая төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 612.2 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2025 оны 730 дугаар тогтоолоор баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу өөрийн хөрөнгөөр 26 нэр төрлийн 341 ширхэг буюу 1,554.7 сая төгрөгийн биет хөрөнгө, 2 ширхэг программ хангамж 156.7 сая төгрөгөөр тус тус худалдан авсан байна. ТӨБЗГ-ын 2025 оны 224 дугаар тушаалын дагуу 30.0 сая төгрөгийн үнэ бүхий 1 ширхэг авто машиныг балансаас балансад шилжүүлэн авснаар нэмэгдэж, тайлант онд 1,129.2 сая төгрөгийн элэгдэл байгуулснаар буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл оны эхнээс 4,042.1 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд барилгуудад зохиогчийн хяналт, зургийн зохиогч, экспертизийн ажлын төлбөрүүд нь барилгын ажил бүрэн дуусаагүй, гүйцэтгэл дуусаагүйтэй холбоотой.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй ажлуудын зохиогчид болон орон нутгийн ГХБХБГ-т техник хяналтын зардалд өгөх өглөгийн үлдэгдэл 1,634.7 сая төгрөг болон ХББОСЯ-нд төвлөрүүлэх нормчлолын сангийн үлдэгдэл 20,533.4 сая төгрөг болж, өмнөх оноос 6,169.3 сая төгрөгөөр өссөн нь нийт өр төлбөр өсөхөд голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо данс нь 2,078.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 224 дугаар тушаалын дагуу 30.0 сая төгрөгийн авто машиныг балансаас балансад шилжүүлэн авсан, тайлант оны цэвэр ашиг 4,011.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, 1,962.3 сая төгрөгийн ногдол ашгийг ТӨБЗГ-т төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2025 онд 1,962.3 сая төгрөг төвлөрүүлэхээр шийдвэрлэснийг 100 хувь төвлөрүүлж ажилласан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 730 дугаар тогтоолоор нийт орлогыг 30,265.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 28,369.4 сая төгрөгөөр, 1,700.8 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллахаар баталсан байна.

Тайлант онд гүйцэтгэлээр 30,363.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 25,908.7 сая төгрөгийн зардал гаргаж, 4,011.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан. Гүйцэтгэлээр 30,363.3 сая төгрөгийн нийт орлого бүрдүүлсэн нь төлөвлөгөөнөөс 0.32 хувиар давсан байна. Үүнд:

Бүтээгдэхүүн баталгаажуулалтын алба нь тохирлын гэрчилгээний хүсэлтийг цахимаар хүлээн авч, 96 аж ахуйн нэгж, байгууллагын 125 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгосон, 162 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу технологийн зааварчилгаа олгон 2025 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр барилга байгууламжийн паспортжуулалт, техникийн дүгнэлт гаргаж ажиллаж бүтээгдэхүүн баталгаажуулалтын орлогын төлөвлөгөөг 58.5 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Барилга байгууламж, зураг төсөл магадлалын хэлтэс нь Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн төсөвтэй холбоотой 1432, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 1264 төсөл, арга хэмжээний зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааг тайлант хугацаанд зохион байгуулсан. Зураг төслийн магадлалын үнийг Барилга, хот байгуулалтын сайдын 108 дугаар тушаалаар баталсан БД81-16-20 дугаартай зураг төслийн ажлын жишиг үнээр тооцон хэрэгжүүлсэн. Зураг төсөл магадлалын орлого нь төлөвлөснөөсөө 29.0 хувиар буюу 959.6 сая төгрөг, бусад орлого төлөвлөснөөсөө 8.0 хувиар буюу 221.9 сая төгрөгөөр тус тус давж биелсэнтэй холбоотой.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар;

ТӨБЗГ-ын 2025 оны 01 сарын 22-ны өдрийн 30 дугаар тушаалаар тус төвийн орон тоог 273 байхаар 14,746.4 сая төгрөгийн цалингийн зардлыг баталсан бол, 2025 оны 641 дүгээр тушаалаар орон тоог 222 байхаар баталж, 385.9 сая төгрөгийн цалингийн зардлыг хэмнэсэн байна.

Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар;

Барилгын хөгжлийн төвийн захирлын 2025 оны Б/51 тоот тушаал "Албан хаагчдад нийтийн тээвэр, хоолны үнийн хөнгөлөлт олгох тухай" тушаалын дагуу 1.0 мянган төгрөгөөр тооцон унааны мөнгө, 14.0 мянган төгрөгөөр тооцон хоолны мөнгө олгодог бөгөөд 818.9 сая төгрөгийн унаа, хоолны зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 793.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны талаар;

Тус төв нь тайлант онд 21 арга хэмжээний зардалд 551.8 сая төгрөг төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 541.0 сая төгрөгийн зарцуулсан байна. Барилгын салбарын мэдээллийн нэгдсэн сан, Захиалагчийн хяналтын мэдээллийн сан программ хангамжуудын сургалт, хэвлэлийн эх бэлтгэлийн сургалт, Мэдээллийн аюулгүй байдал программ хангамж хөгжүүлэлт, чадавхжуулах сургалт, BIM-н олон улсын туршлага, гарах үр дүн сэдэвт сургалт зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын үйл ажиллагааг сайжруулах үндсэн хөрөнгөтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Өлзийт экаунт ХХК-ийн ахлах аудитор Ч.Оюун, аудитор Б.Төрмөнх, аудитын шинжээч Д.Мандахбаяр нар гүйцэтгэж, компанийн чанарын хяналтын менежер Ц.Бямбажав анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Долгоржав, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 01/318 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 25,034.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 250.3 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тайлант хугацаанд шуудан харилцаа холбооны зардлыг 7.7 сая төгрөг, цалин хөлс нийгмийн даатгалын зардлыг 385.9 сая төгрөг, зар сурталчилгааны зардлыг 81.6 сая төгрөг, гадаад дотоод томилолтыг 391.5 сая төгрөг, нормын хувцас хэрэглэлийн зардлыг 137.7 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд сар бүр оруулах 24, хагас жилд оруулах 3, санхүүгийн жилд оруулах 11, тухай бүр оруулах 144 мэдээлэл буюу нийт 182 мэдээлэл оруулахаас 180 мэдээллийг хуулийн хугацаанд баталгаажуулан мэдээлж, 2 мэдээлэл хугацаа болоогүй хүлээгдэж байна. Хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй, иж бүрэн үнэн зөв мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд дараах асуудлууд илэрсэн. Үүнд:

Тус байгууллага нь 86.0 сая төгрөгийн тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулж, батлахдаа оролцогчийн ерөнхий шаардлагад "Хүүхэд хамгааллын бодлого" баталж ирүүлэхийг тусгаагүй, оролцогчоос шаардаагүй байна. Энэ нь ТБОНӨБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1.10-т "Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасан хүүхэд хамгааллын бодлого батлаагүй хуулийн этгээд" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн баримт бичгийн ерөнхий шаардлагад хүүхэд хамгааллын бодлого шаардаагүй, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, зардал, орлогын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 442.5 сая төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс жилийн эцсийн аудитаар дахин үнэлэхэд бүрэн хэрэгжүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 41.6 сая төгрөгийн зөрчил илэрч төсөвт төвлөрүүлэх 1 төлбөрийн акт, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлснийг 100 хувь биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	5,526.9	1	5,526.9	100.0
Албан шаардлага	1	8,434.3	1	8,434.3	100.0
Зөвлөмж	2	27,657.5	2	27,657.5	100.0
Нийт дүн	4	41,618.7	4	41,618.7	100.0

4.5.3 Худалдан авах ажиллагаа

“Барилгын хөгжлийн төв” ТӨААТҮГ-ын захирлын 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/589 дүгээр тушаалаар төвийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тодотгож баталсан. Нийт 19,100.0 сая төгрөгийн үнэ бүхий 342 төсөл арга хэмжээ буюу бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгөөгөө батлуулсан. Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 21 төсөл арга хэмжээний дүнд 6,006.0 сая төгрөг, харьцуулалтын аргаар 50 төсөл арга хэмжээнд 2,204.2 сая төгрөг, ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс 2 төсөл арга хэмжээнд 412.1 сая төгрөг, нэг эх үүсвэрээр 2 төсөл арга хэмжээнд 135.0 сая төгрөг, шууд худалдан авалтаар 142 төсөл арга хэмжээнд 1,646.5 сая төгрөгийн хөрөнгөөр бараа материал тус тус худалдан авч, 217 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан нийт 10,403.9 сая төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Монгол Улсын Засгийн газрын 267 дугаар тогтоолын дагуу газрын кадастрын мэдээллийн санг WGS-84 солбилцол болон UTM тусгагт шилжүүлсэнтэй холбоотойгоор газрын талбайн хэмжээ 26 м.кв буурсан, мөн орон сууцны зориулалттай газрын хэмжээ 61,165 м.кв болон нэмэгдсэн өөрчлөлтийг санхүүгийн тайланд дээд газрын зөвшөөрлийн дагуу бүртгэсэн эсэх;
- Санхүүгийн тайланд бүртгэлтэй байгаа нормчлолын сангийн данснаас ХББОСЯ-ны төрийн нарийн бичгийн даргын албан бичгээр хийгдсэн, нийт 2,786.9 сая төгрөгийн зарлагын гүйлгээг тулган баталгаажуулах захидал хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй;
- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн Нэмж төлөгдсөн капитал дансанд 2017 оноос эхлэн бүртгэсэн 195.5 сая төгрөгийн гүйлгээг бүртгэх болсон үндэслэл, холбогдох баримт бичгийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 333.7 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 273.6 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 60.1 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 333.7 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 250.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Санхүүгийн тайлангийн завсрын аудитаар иргэний ирүүлсэн гомдлын дагуу шалгахад төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн асуудалд албан шаардлага өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.1 Албан шаардлага

1.Инженер техникийн ажилтны сургалт зохион байгуулах БХТ/20250203099 тоот тендер зохион байгуулан, амралтын газар шалгаруулж, нийт 95.8 сая төгрөгийн сургалтын зардал төлсөн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

2.Тус байгууллага нь төсвийн хөрөнгөөр "ВІМ-ын олон улсын туршлага, гарах үр дүн сэдэвт сургалт зохион байгуулах" тендерийг жил бүр 59.6 сая төгрөгөөр зохион байгуулах шаардлагагүй бөгөөд байгууллага нь тусгай эрхээ худалдан авах замаар төсвийн хөрөнгийг хэмнэж ажиллах боломжийг ашиглаагүй байна.Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тусгай эрхийг худалдан авах замаар сургалтын зардлыг хэмнэж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.Инженерийн энгэрийн тэмдгийн үлдэгдэл 3053 ширхэг байхад нэмж 2000 ширхгийг 46.0 сая төгрөгөөр худалдан авч их хэмжээний нөөц үүсгэсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын үлдэгдлийг харгалзахгүй худалдан авалт хийж, нөөц үүсгэсэн зөрчлийн давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.Тайлангийн хугацаанд 49.2 сая төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог бодож, тайланг гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахууны зарцуулалтын тооцоог бодож, тайланг бэлтгээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

5. Тус байгууллага нь 19.0 сая төгрөгийн урьдчилж орсон сургалтын төлбөрийн хуримтлагдсан өрийг жилийн эцэст тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан,мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2. 5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулна " гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

6.Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээнээс түүвэрлэн шалгахад 3.9 сая төгрөгийн хурал, арга хэмжээний зардлын төсвийг батлаагүй зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д "Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Арга хэмжээний зардлын төсвийг батлаагүй, зардал гаргасан зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын элэгдлийн хугацаа болон байгууллагын тооцсон элэгдлийн хугацааны зөрүү 60.1 сая төгрөгийг санхүү болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд тайлагнаагүйгээс татвар дутуу тайлагнасан. НББОУС-16 Үндсэн хөрөнгө-ийн 16.50-д "Хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглахаар тооцсон хугацааны туршид

системтэйгээр хуваарилна”, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Албан татвар төлөгчийн нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд ашиглах хөрөнгөд элэгдэл, хорогдлыг дараах байдлаар тооцно” гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт хөрөнгийн элэгдлийг ангилал тус бүрээр тусган, тайлант хугацаанд төлөх татварыг зөв тодорхойлон ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Инженерийн энгэрийн тэмдгийн үлдэгдэл 3053 ширхэг байхад нэмж 2000 ширхгийг 46,000.0 мянган төгрөгөөр худалдан авч их хэмжээний нөөц үүсгэсэн байна	1	46,000.0			1	46,000.0							
Тайлангийн хугацаанд 49,221.9 мянган төгрөгийн шатахууны тооцоог бодож, тайланг бэлтгээгүй байна.	1	49,221.9			1	49,221.9							
Тус байгууллага нь 19,011.9 мянган төгрөгийн урьдчилж орсон сургалтын төлбөрийн хуримтлагдсан өрийг тооцоо нийлэн баталгаажуулаагүй байна.	1	19,011.9			1	19,011.9							
"ВІМ-ын олон улсын туршлага, гарах үр дүн сэдэвт сургалт зохион байгуулах" тендерийг жил бүр төсвийн хөрөнгөөр зохион байгуулах шаардлагагүй бөгөөд	1	59,640.0			1	59,640.0							

Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

байгууллага нь тусгай эрхээ худалдан авах замаар хөрөнгийг хэмнэн ажиллаагүй байна.											
2025 оны 08 дугаар сарын 29-ны өдөр Инженер техникийн ажилтны сургалт зохион байгуулах БХТ/20250203099 тоот тендер зохион байгуулан, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг компани шалгаруулж, нийт 95,800.0 мянган төгрөгийн сургалтын зардал төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна.	1	95,800.0			1	95,800.0					
Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээнээс түүвэрлэхэд 3,903.3 мянган төгрөгийн хурал, арга хэмжээний зардлын төсвийг батлаагүй зарцуулсан байна.	1	3,903.3			1	3,903.3					
Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын элэгдлийн хугацаа болон байгууллагын тооцсон элэгдлийн хугацааны зөрүү 60,147.9 мянган төгрөгийг санхүү болон татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланд тайлагнаагүйгээс татвар дутуу тайлагнасан.	1	60,147.9					1	60,147.9			
Дүн	7	333,725.0			6	273,577.1	1	60,147.9			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулж батлахдаа оролцогчийн ерөнхий шаардлагад "Хүүхэд хамгааллын бодлого" баталж ирүүлэхийг тусгаагүй байна.	1	86,000.0			1	86,000.0		
Дүн	1	86,000.0			1	86,000.0		



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 797/A0150185

Улаанбаатар хот

САГ -2026/15/НА -СТА -ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд, хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь инженерийн энгэрийн тэмдгийн үлдэгдэл 3053 ширхэг байхад нэмж 2000 ширхгийг 46,000,000.00 /дөчин зургаан сая/ төгрөгөөр худалдан авч их хэмжээний нөөц үүсгэсэн /жилд 110 ширхэг зарцуулдаг/ байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Бараа материалын үлдэгдлийг харгалзахгүй худалдан авалт хийж, нөөц үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Д.Мөнхбаатар/, Санхүү, эдийн засаг, аж ахуйн хэлтсийн дарга /О.Одхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ч.ЭРДЭНЭЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 796/A015 0185

Улаанбаатар хот

САГ -2026/15/НА - СТА -ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд, хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлангийн хугацаанд 49,221,926.00 /дөчин есөн сая хоёр зуун хорин нэгэн мянга есөн зуун хорин зургаан/ төгрөгийн шатахууны зарцуулалтын тооцоог бодож, тайлан гаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шатахууны зарцуулалтын тооцоог бодож, тайлан гаргаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Д.Мөнхбаатар/, Санхүү, эдийн засаг, аж ахуйн хэлтсийн дарга /О.Одхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГ

Ч.ЭРДЭНЭЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 793/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/15/НА - СТА - ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд, хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 19,011,935.00 /арван есөн сая арван нэгэн мянга есөн зуун гучин таван/ төгрөгийн урьдчилж орсон сургалтын төлбөрийн хуримтлагдсан өрийг жилийн эцэст тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2. 5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан, баталгаажуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "Авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өр төлбөрийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Д.Мөнхбаатар/, Санхүү, эдийн засаг, аж ахуйн хэлтсийн дарга /О.Одхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Ч.ЭРДЭНЭЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 795/А0150185

Улаанбаатар хот

САГ - 2026/15/ИА - СТА - ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд, хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь төсвийн хөрөнгөөр "BIM-ын олон улсын туршлага, гарах үр дүн сэдэвт сургалт зохион байгуулах" тендерийг жил бүр 59,640,000.00 /тавин есөн сая зургаан зуун дөчин мянган/ төгрөгөөр зохион байгуулах шаардлагагүй бөгөөд байгууллага нь тусгай эрхээ худалдан авах замаар төсвийн хөрөнгийг хэмнэж ажиллах боломжийг ашиглаагүй байна.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн," Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Тусгай эрхийг худалдан авах замаар сургалтын зардлыг хэмнэж ажиллаагүй, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Д.Мөнхбаатар/, Санхүү, эдийн засаг, аж ахуйн хэлтсийн дарга /О.Одхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Ч.ЭРДЭНЭЖАВ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-47.Docx

1526181052



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 792/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/15/КА-СТА-ТВА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ 2025 оны санхүүгийн тайланд, хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Инженер техникийн ажилтны сургалт зохион байгуулах БХТ/20250203099 тоот тендер зохион байгуулан, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг компани шалгаруулж, нийт 95,800,000.00 /өрэн таван сая найман зуун мянган/ төгрөгийн сургалтын зардал төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.7-д "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулаагүй, төсвийг хэмнээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Д.Мөнхбаатар/, Санхүү, эдийн засаг, аж ахуйн хэлтсийн дарга /О.Одхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ

Ч.ЭРДЭНЭЖАВ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 794/А0150185

Улаанбаатар хот

САГ-2026/15/НА -СТА-ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ 2025 оны санхүүгийн тайланд, хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээнээс түүвэрлэн шалгахад төсөв батлаагүй, 3,903,300.00 /гурван сая есөн зуун гурван мянга гурван зуун/ төгрөгийг хурал, арга хэмжээнд зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д "Төрийн өөрийн өмчийг зориулалт бусаар захиран зарцуулах, нийгмийн шинжтэй төсөл, арга хэмжээнд зарцуулах, хандив, тусламж, түүнтэй адилтгах хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглох бөгөөд энэхүү хориглолтыг зөрчсөн эрх бүхий этгээдийг албан тушаалаас чөлөөлж, учруулсан хохирлыг нөхөн төлүүлнэ", Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01 тоот албан даалгаврын 2.6-д "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн үрэлгэн байдал, хэрэгцээгүй худалдан авалт, гадаад томилолтыг хязгаарлаж, тансаглалыг таслан зогсоох талаар харьяа байгууллага, хуулийн этгээдийн удирдлагад үүрэг өгч, үр дүнг тооцож ажиллах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "Нягтлан бодох бүртгэлийг холбооцоо стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хурал, арга хэмжээний зардлын төсвийг батлуулаагүй, төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Д.Мөнхбаатар/, Санхүү, эдийн засаг, аж ахуйн хэлтсийн дарга /О.Одхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙГ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГ
Ч.ЭРДЭНЭЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316\SAG-47.Docx

1526181056



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 798/A0150185

Улаанбаатар хот

САГ-2026/15/КА - СТА -ТӨА

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд, хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Тус байгууллага нь 86,000,000.00 /наян зургаан сая/ төгрөгийн тендер шалгаруулалтын баримт бичиг боловсруулж, батлахдаа оролцогчийн ерөнхий шаардлагад "Хүүхэд хамгааллын бодлого" баталж ирүүлэхийг тусгаагүй, оролцогчоос шаардаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчин хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ", 7.1.10-т "Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасан хүүхэд хамгааллын бодлого батлаагүй хуулийн этгээд" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээн" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тендерийн баримт бичгийн ерөнхий шаардлагад хүүхэд хамгааллын бодлогыг шаардаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын захирал /Д.Мөнхбаатар/, Санхүү, эдийн засаг, аж ахуйн хэлтсийн дарга /О.Одхүү/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ч.ЭРДЭНЭЖАВ